

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана.” гэж, Тавин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд **аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд** хуваагдана.” гэж тус тус заасан. Ийнхүү төрийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах зорилгоор Үндсэн хуульд засаг захиргааны нэгжийг тодорхой, **хатуу байдлаар** тогтоосон байдаг.

Өмнө нь үйлчилж байсан /2006 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан, 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон) Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж” гэсэн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.” гэж, 3.2 дахь хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.” гэж, 3.4 дэх хэсэгт “Баг нь сумын, хороо нь дүүргийн засаг захиргааны нэгж мөн.” гэж зааж Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд **аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд** хуваагдана.” гэсэн заалт, үзэл баримтлалыг органик хуульдаа бататган хуульчилсан байсан.

Харин 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын “**Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**” гэсэн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад ““нэгж” гэж аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороог” ойлгоно гэж тодорхойлоод мөн хуулийн **11 дүгээр зүйлийн 11.1** дэх хэсэгт “Хороо нь иргэдэд хуульд заасан үйлчилгээ хүргэх, нутгийн өөрийн удирдлагад иргэдийн оролцоог хангах чиг үүрэг бүхий анхан шатны нэгж мөн.”, 11.2 дахь хэсэгт “Хороо нь хэсгийн зохион байгуулалттай байна. Хэсгийн хуваарийг хүн амын суурьшил, өрхийн тоог харгалзан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.” гэж заасан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн “Хороо нь хэсгийн зохион байгуулалттай байна.” буюу хороо нь цаашаа “хэсэгт” хуваагдана гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан “Нийслэл -> Дүүрэг -> Хороо” гэсэн гурван шатлалыг дөрөв болгож, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд **аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд** хуваагдана.” гэсэнтэй зөрчилдөж байх тул Монгол

Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Уг хуулийн төсөл 3 зүйлтэй бөгөөд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн “хорооны хэсэг”-тэй холбоотой хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1.20 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцох, 32 дугаар зүйлийн 32.9 дэх хэсэгт өөрчлөлт оруулахаар тусгасан. Хуулийн төслийн 3 дугаар зүйлд хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хугацааг тусгасан.

Хуулийн төсөлтэй хамт Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “Нийслэл нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана. Хороо нь хэсгийн зохион байгуулалттай байна.” гэсний 2 дахь өгүүлбэрийг хасах өөрчлөлтийг тусгасан Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хамт тус тус боловсруулсан болно.

---oOo---